



Долоо хоног тутмын хэвлэл  
2015 оны 07 дугаар сарын 10  
№26 /887/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

1226

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1236

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1277

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1286

**Эрчим хүчний тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай**

**Монгол Улсын эдийн засаг,  
нийгмийг 2016 онд хөгжүүлэх  
үндсэн чиглэлийг батлах тухай**

**Төрөөс аж үйлдвэрийн талаар  
баримтлах бодлого батлах  
тухай**

**Төрөөс эрчим хүчний талаар  
баримтлах бодлого батлах  
тухай**



**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

316.	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1226
317.	Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай	1233
318.	Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1234
319.	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1234
320.	”Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	1236

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

321.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай	Дугаар 52	1236
322.	Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай	Дугаар 60	1276
323.	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 62	1277
324.	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 63	1286

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

325.	Шүүгч нарыг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 110	1297
326.	Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 111	1310



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг:**

“2.4. Эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх, хэмнэхтэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.”

#### **2/3 дугаар зүйлийн 3.1.30-3.1.34 дэх заалт:**

“3.1.30. “хийн хангамжийн дүрэм” гэж метан хийн хангамжийн бүрэлдэхүүн хэсгийн хяналтын нэгдсэн зохицуулалт, техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг;

3.1.31. “хийн хангамжийн сүлжээ” гэж метан хийг боловсруулах, цэвэрлэх, хадгалах, тээвэрлэх, дамжуулах, түгээх шугам, тоног төхөөрөмж бүхий төлөвлөлт, эдийн засаг, удирдлага, зохицуулалтын нэгдмэл үйл ажиллагааг;

3.1.32. “магадлал” гэж эрчим хүчний барилга байгууламж, түүнд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, техник, технологи, нэгдсэн төсөв нь норм, дүрэм, стандартын шаардлага хангасан талаар мэргэшсэн шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагааг;

3.1.33. “бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч” гэж эрчим хүч экспортлох, эсхүл гэрээний хугацаанд хэлцлийн үнээр эрчим хүч нийлүүлэх хувийн хэвшлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай эрчим хүч үйлдвэрлэгчийг;

3.1.34. “эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” гэж бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчээс урт хугацаанд эрчим хүч худалдан авах гэрээг.”

#### **3/5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт:**

“5.1.6. бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.”

**4/6 дугаар зүйлийн 6.1.15 дахь заалт:**

“6.1.15.эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг холбогдох байгууллагад олгох;”

**5/6 дугаар зүйлийн 6.1.18 дахь заалт:**

“6.1.18.хийн хангамжийн сүлжээнд нийлүүлэх хийн холболтын болон хүргэлтийн эцсийн цэг, байршлыг батлах, гэрээ байгуулах шийдвэр гаргах.”

**6/9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалт:**

“9.1.19.тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэл, суурь зарчмыг техник, эдийн засгийн хувьд үр ашигтай, оновчтой байх нөхцөлийг шалгуур болгон тогтоох;”

**7/9 дүгээр зүйлийн 9.1.21, 9.1.22 дахь заалт:**

“9.1.21.бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй байгуулах эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загварыг батлах, гэрээг бүртгэх;

9.1.22.бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг баталгаажуулах.”

**8/10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэг:**

“10.3.Диспетчерийн үндэсний төв нь диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, тухайн жилийн төсвөө эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүнд жил бүр тайлагнана.

10.4.Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчээс сүлжээнд нийлүүлэх эрчим хүчийг энэ хуулийн 6.1.15-д заасны дагуу эрх авч гэрээ байгуулан, уг гэрээний дагуу зохицуулна.”

**9/12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалт:**

“12.1.12.хийгээр хангах.”

**10/14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг:**

“14.4.Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.”

**11/15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалт:**

“15.2.5.нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;”

**12/18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт:**

“18.2.3.хэрэглэгчийг метан хийгээр гэрээний дагуу хангах.”

**13/27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг:**

“27.8.Метан хийн үнэ тарифыг шингэн, шахсан, хийн төлөв байдал бүрээр хэрэглээний зориулалт, хангамжийн бүтцийг харгалзан тогтооно.”

**14/29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт:**

“29.1.9.хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.”

**15/30 дугаар зүйлийн 30.1.13 дахь заалт:**

“30.1.13.нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.”

**16/37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсэг:**

“37.2.Энэ хуулийн 33.1 дэх хэсгийг зөрчвөл хамгаалалтын зурвас дахь барилга байгууламжийг буулгуулж, зурвасыг чөлөөлүүлнэ.

37.3.Хэрэглэгч нь эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцөл шаардлагын дагуу холбогдоогүй, хүчин чадлыг дур мэдэн нэмэгдүүлснээс эрчим хүч түгээх, хангах байгууллагад хохирол учруулсан, хохирлыг барагдуулах тухай шаардлагыг биелүүлээгүй нь нотлогдвол тухайн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “цахилгаан дамжуулах зориулалт бүхий” гэсний өмнө “нэгдсэн сүлжээ үүсгэж байгаа” гэж, 3.1.8 дахь заалтын “хүртэлх” гэсний дараа “цахилгаан түгээх зориулалт бүхий 110кВ, түүнээс доош” гэж, 3.1.22 дахь заалтын “үйлдвэрлэгчийн үнэ,” гэсний дараа “дэмжих тариф” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “нэгдсэн сүлжээ,” гэсний дараа “хийн хангамж,” гэж, “аюулгүй ажиллагааны” гэсний дараа “болон магадлал хийх” гэж, 6.1.12 дахь заалтын “дүн шинжилгээ хийх” гэсний дараа “ажлыг



зохион байгуулах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохицуулах” гэсний дараа “, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.18 дахь заалтын “зохицуулалттай үйлчилгээний” гэсний дараа “хөлс тооцох аргачлал, уг үйлчилгээний” гэж, 9.1.19 дэх заалтын “төсвийн гүйцэтгэлийг” гэсний дараа “эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Диспетчерийн үндэсний төв нь” гэсний дараа “нэгдсэн сүлжээгээр эрчим хүч импортлох, экспортлох,” гэж, 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын “эрчим хүчээр” гэсний өмнө “стандартын шаардлагад нийцсэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт:**

“3.1.1. “эрчим хүч” гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг;”

**2/3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт:**

“3.1.5. “нэгдсэн сүлжээ” гэж цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний нэгдлийг;”

**3/5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт:**

“5.1.5. эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг гаргах судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах;”

**4/6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалт:**

“6.1.14. эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулах, магадлал хийх ажлыг зохион байгуулах;”

**5/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3. Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд энэ хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зохицуулах хороо олгоно.”



**6/12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэг:**

“12.6.Хэрэглэгчийн өөрийн технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тухайн хуулийн этгээдэд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдэд цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй.”

**7/19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг:**

“19.2.Бүс нутгийн цахилгаан дамжуулах сүлжээгээр цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийг тухайн сүлжээний дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгоно.”

**8/25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалт:**

“25.1.5.нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан, хийн хангамжийн дүрмийн дагуу эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах;”

**9/26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг:**

“26.1.Тарифыг эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хангах үйл ажиллагаа тус бүрээр тогтооно.”

**10/26 дугаар зүйлийн 26.2.4 дэх заалт:**

“26.2.4.үнийг инфляцтай уялдуулан тооцох;”

**11/29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг:**

“29.2.Эрчим хүчээр хангагч нь хууль тогтоомжид заасан, орон нутгийн удирдлага, мэргэжлийн хяналтын болон хуулийн байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гэрээнд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахыг хориглоно.”

**12/36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг:**

“36.1.Хэрэглэгчийн аль нэгний буруутай үйлдлээр эрчим хүч тасалдсан бол буруутай тал нь хохирлыг нөхөн төлнө. Хохирлын хэмжээг эрчим хүчээр хангагч, хэрэглэгч хамтран тогтоож, актаар баталгаажуулсан байна.”

**13/37 дугаар зүйлийн 37.1.1-37.1.6 дахь заалт:**

“37.1.1.тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл тусгай зөвшөөрлөө бусдад шилжүүлсэн буюу бусдын тусгай



зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулсан, эрх бүхий байгууллагаас хянаж баталснаас өөр үнэ, тарифаар эрчим хүчийг борлуулсан бол олсон борлуулалтын орлогыг хурааж, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

37.1.2.эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн шаардлага, өгсөн үүргийг биелүүлээгүй, хяналт шалгалт хийхэд саад учруулсан, бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах журам зөрчсөн, санаатайгаар худал ташаа мэдээлэл гаргаж өгсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

37.1.3.энэ хуулийн 30.1-д заасан болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

37.1.4.хууль тогтоомж, гэрээ, тусгай зөвшөөрөлд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарласан, энэ хуулийн 32.1-32.3-т зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлсэн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

37.1.5.эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг нь алдагдуулсан, зөвшөөрөлгүйгээр эрчим хүч хэрэглэсэн, шугам сүлжээг хамгаалах, цахилгаан, дулаан хэрэглэх дүрмийг зөрчсөн, хамгаалах зурваст газар олгосон бол хууль бусаар хэрэглэсэн эрчим хүчний үнэ, учруулсан хохирлыг нөхөн төлүүлж буруутай иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх





хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

37.1.6. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, энэ хуулийн 25.1.3, 25.1.4, 25.1.6, 25.1.7, 25.1.9, 25.1.10-т заасан үүрэг, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны норм, стандарт, дүрэм, журам, Зохицуулах хорооны тогтоолыг зөрчсөн, үйлдвэрлэлийн осол, аваар гаргасан, эд хөрөнгийн хохирол учруулсан, техникийн гэмтэл гарахад хүргэсэн бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж буруутай иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

**4 дүгээр зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.28 дахь заалтын “тоног төхөөрөмжийг” гэснийг “тоног төхөөрөмж, бэлтгэл чадлыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “цахилгаан, дулаан” гэснийг “эрчим хүч” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “норм, нормативыг батлах” гэснийг “нормативын баримт бичгийг батлах” гэж, 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “үйлчилгээний төлбөрөөр” гэснийг “үйлчилгээний хөлсөөр” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хурлаар” гэснийг “хурлаараа” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Зохицуулах зөвлөлийн ажиллах журам,” гэснийг “Зохицуулах зөвлөлийг байгуулах,” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалтын “холболтын зааврыг” гэснийг “холболтын журмыг” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “өмч байна” гэснийг “өмч байж болно” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Цахилгаан эрчим хүчээр” гэснийг “Эрчим хүчээр” гэж, “цахилгааны борлуулалтыг” гэснийг “цахилгаан, дулааны борлуулалтыг” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “санхүүгийн чадавхтай,” гэснийг “энэ хуулийн 21.2-т заасан шаардлага хангасан,” гэж, 21.3 дахь хэсгийн “Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл” гэснийг “Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн 26.2.6 дахь заалтын “цахилгаан, дулааны” гэснийг “эрчим хүчний” гэж, мөн зүйлийн 26.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “Зохицуулах газар” гэснийг “Зохицуулах хороо” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “хүсэлт гаргасан тохиолдолд 3 сард нэг удаа” гэснийг “хүсэлт гаргасан тохиолдол бүрд” гэж, 27.4 дэх хэсгийн “Зохицуулах газарт” гэснийг “Зохицуулах хороонд” гэж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “эрчим хүч дамжуулах шугам сүлжээний” гэснийг “эрчим хүчний шугам сүлжээний”



гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтын “4-өөс” гэснийг “24-өөс” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “тогтооно” гэснийг “баталгаажуулна” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “эрчим хүчний улсын хяналтын байгууллага,” гэснийг “эрх бүхий албан тушаалтан,” гэж, 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийн дугаарыг “2.5” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.15, 6.1.16 дахь заалтын дугаарыг “6.1.16, 6.1.17” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалтын дугаарыг “9.1.20” гэж, 9.1.20 дахь заалтын дугаарыг “9.1.23” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.5-15.2.7 дахь заалтын дугаарыг “15.2.6-15.2.8” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “үйл ажиллагааны болон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “тохиолдолд 12.1-д заасан” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “тоолуураар хэрэглэгчийг хангах,” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.2.7 дахь заалтын “, диспетчерийн зохицуулалт хийх” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн осол гарах болон” гэснийг, 32.1.4 дэх заалтын “удаа дараа” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмсүгэй:

“6.3.Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “дулаан,” гэсний дараа “хий,” гэж нэмсүгэй:

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:**

“4.1.9. “дэмжих тариф” гэж сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг.”

#### **2/5 дугаар зүйлийн 5.6.3, 5.6.4 дэх заалт:**

“5.6.3. хэрэглэгчийн худалдан авах дэмжих тарифын хэмжээг тогтоох;

5.6.4. цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний үйлчлэх хугацаа дууссаны дараа үнэ, тарифыг тухай бүр тогтоох.”

#### **3/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3. Гэрээний хугацааг хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно.”



#### **4/11 дүгээр зүйлийн 11.6, 11.7 дахь хэсэг:**

“11.6.Эрчим хүчний системд холбогдох болон горим тохируулагч усан цахилгаан станцын үнэ, тарифыг бодит өртөг, техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан Эрчим хүчний зохицуулах хороо тогтооно.

11.7.Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан үнэ, тарифын хязгаарыг хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно.”

**2 дугаар зүйл.**Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/5 дугаар зүйлийн 5.3.5 дахь заалт:**

“5.3.5.Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг хэрэгжүүлэх болон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, журмыг боловсруулж, батлах.”

#### **2/5 дугаар зүйлийн 5.3.7 дахь заалт:**

“5.3.7.сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар, үйлчилгээний норм, дүрэм, стандартыг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих.”

#### **3/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:**

“11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгоно.”

#### **4/12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:**

“12.1.Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө.”

**3 дугаар зүйл.**Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Эрчим хүчний зохицуулах газар” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “7.3.2 дахь заалт” гэснийг “11.2 дахь хэсэг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “эрчим хүчний зохицуулах газраас баталсан” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл” гэж тус тус өөрчилсүгэй.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### “ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ”-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.



3.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

4.Үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийхдээ Төрийн аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлан, биелэлтийг албан тушаалтны үүрэг, хариуцлагатай холбон дүгнэж байхыг Үндэсний аудитын газар /А.Зангад/-т үүрэг болгосугай.

5.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/Тухайн жилд хэрэгжих боломж, бодит байдлыг харгалзан, зорилт, арга хэмжээ бүрийн хүрэх түвшин, түүний биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, үргэлжлүүлэн санхүүжүүлэх зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дараа жилийн төсвийн тухай хуульд нэмж тусгаж байх;

2/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын байгууллагын чадавхыг сайжруулах арга хэмжээ авах;

3/Төрийн байгууллагуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, төрийн албаны шат бүрд ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол үнэлдэг тогтолцоог бий болгох.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

	2	3	4	5	6	7
Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2016 онд хүрэх түвшин, үр дүн	2016 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтална.</b>						
1.1	"Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого" /цаашид "ҮХЦБ" гэх/-ын 5.1 дэх заалт	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт, хувиар Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллар	5.0  4400	-  -	Сангийн яам /цаашид "СЯ" гэх/, Бусад бүх яамд
1.2	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" /цаашид "ЗГҮАХХАХТ" гэх/-ий 145 дахь заалт	Ажлын байрыг хадгалах зарчим баримталж, ажилгүйдлийн түвшинг бууруулах	Ажилгүйдлийн түвшин, хувиар	7.0	-	Хөдөлмөрийн яам /цаашид "ХЯ" гэх/, Бусад бүх яамд

1.3	ЗҮГАХХАХТ-ний 12.1 дэх заалт	Инфляцийг онцлон мөнгөний бодлого хэрэгжүүлэх	Инфляцийн зорилгот төвшин, оны эцэст	Нэг оронтой тоонд байлгах	-	Монголбанк
1.4	ҮХЦБ-ын 5.1.3 дахь зорилт	Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй болгох бодлого баримтлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Монголбанк, Бүх яамд
1.5	ЗҮГАХХАХТ -ний 1.1 дэх заалт	Татварын шинэчлэлийг гүнзгийрүүлж, энгийн ойлгомжтой, олон улсын жишигт нийцүүлэх замаар бизнес эрхлэгч, бага орлоготой иргэдийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ
1.6	ҮХЦБ-ын 5.1.4 дэх заалт, Өрийн удирдлагын Тухай хуулийн 14.2 дахь хэсэг	Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, дунд хугацаанд учирч болзошгүй төлбөрийн эрсдэлийг бууруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ
1.7	ҮХЦБ-ын 5.1.1 дэх заалт, ЗҮГАХХАХТ-ний 13.1, 13.2 дахь заалт	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх	ДНБ-д нэгдсэн төсвийн Орлогын злэх доод хэмжээ, хувиар  ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын злэх дээд хэмжээ, хувиар	24.6  28.6	-  -	СЯ





			Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар	-4.0	-	
<b>Зорилт 2.Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>						
2.1	ҮХЦБ-ын 5.1.5, 2.2.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 28 дахь заалт	Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум ам.доллар	1.8	-	Хөрөнгө оруулалтын газар /цаашид "ХОГ" гэх/, Уул уурхайн яам, /цаашид "УУЯ" гэх/
2.2	ЗГҮАХХАХТ-ний 24 дэх заалт	Орон нутгийн хөржлийн сангийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "АНЗДТГ" гэх/
2.3	Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.13 дахь заалт	Засгийн газрын өрийн баталгааны сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ

2.4	ЗГҮАХХАХТ-ний 51.1 дэх заалт, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид "ТЭБСББ" гэх/-ын 3.3.2 дахь заалт	Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Ажлын явц, хувиар	20-иос дээш	-	Монгол Улсын сайдын ажлын алба УУЯ
2.5	ЗГҮАХХАХТ-ний 52 дахь заалт	Таван толгойн төслийг үргэлжлүүлэх	Ажлын явц, хувиар	20.0 –иос дээш	-	Монгол Улсын сайдын ажлын алба, УУЯ
2.6	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийн 11.3 дахь заалт/цаашид "ЭЗХГХХ" гэх/	Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/
2.7	ЗГҮАХХАХТ-ний 35 дахь заалт	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ, СЗХ
2.8	Экспортыг дэмжих хөтөлбөрийн 3.1 дэх заалт	Тоног, төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Аж Үйлдвэрийн яам /цаашид "АУЯ" гэх/, СЯ, Хөгжлийн банк



2.9	ЭЗХТАХХ-ийн 2.2 дахь заалт	Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах	Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн зэлэх хувь	5.0-аас доош	-	Монголбанк
2.10	ЗГҮАХХАХТ -ний 35.2 дахь заалт	Нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх	Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын явц, хувиар	100.0	-	СЗХ, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХАХНХЯ" гэж
2.11	ҮХЦБ-ын 4.7.1 дэх заалт, ЗГҮАХХҮАТ-ний 128.1 дэх заалт	Үйлдвэрлэлийн орц болох эрчим хүч, материал, усыг үр ашигтай хэмнэлттэй болгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар	100.0	-	АУЯ, ЭХЯ, БОНХАЖЯ
2.12	ҮХЦБ-ын 5.1.5 дахь заалт	Бизнесийн орчин, эдийн засгийн эрх чөлөөний, өрсөлдөх чадварын зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан индексээр Монгол Улсын өнөөгийн байр суурийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар	100.0	-	СЯ, АУЯ

**Зорилт 3. Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.**

3.1	ЭЗХТАХХ-ийн 10.5 дахь заалт	Тарифын болон тарифын бус саад тотторыг бууруулж, хөрш болон гуравдагч орны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	АҮЯ, Гадаад хэргийн яам /цаашид "ГХЯ" гэх/
3.2	ЗГҮАХХАХТ-ний 61.1, 61.2 дахь заалт	Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээнд багтаан импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ, АҮЯ
3.3	ЗГҮАХХАХТ-ний 58 дахь заалт	"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс, "Алтанбулаг" болон "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулах	Дэд бүтцийн ажлын явц, хувиар	50.0	90.0 Төр хувийн хэвшлийн түншлэл /цаашид "ТХХТ" гэх/	АҮЯ
3.4	ЗГҮАХХАХТ-ний 8.5 дахь заалт	Гадаад худалдааг хөнгөвчлөх "Цахим нэг цонх" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлдэх	Хөтөлбөрийг боловсруулж батлуулах ажлын явц, хувиар	100.0	-	АҮЯ



<b>ХОЁР-ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 4. Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.</b>						
4.1	"Монгол мал" Үндэсний хөтөлбөрийн 3.2.1, 3.2.3 дахь заалт	Үржлийн цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх	Үржлийн үзлэг ангилалтад хамрагдах өсвөр малын тооны өсөлт, хувиар	20.0-иос доошгүй	0.2 Улсын төсөв	Хүнс, хөдөө аж ахуйн яам /цаашид "ХХААЯ" гэх/, АНЗДТГ
			Стандартад нийцэж баталгаажсан хээлтүүлэгчийн тооны өсөлт, хувиар	20.0-иос доошгүй		
4.2	"Монгол мал" Үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт	Төв, суурин газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн хонь, үхрийн болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Эрчимжсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт, хувиар	20.0	2.5 Хувийн хэвшил	ХХААЯ
4.3	"Монгол мал" Үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт	Монгол малын генийн санг хамгаалах, малын нөхөн үржилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэх	Малын удмын сангийн үндэсний цогцолбор барих ажлын явц, хувиар	100.0	1.3 Улсын төсөв	ХХААЯ

4.4	“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн 3.4 дэх заалт	Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	Тусгай хэрэгцээнд шинээр авах бэлчээрийн талбайн хэмжээ, мянган га  Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар	50 –иас доошгүй	0.3 Улсын төсөв	ХХААЯ
4.5	“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн 3.3.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 78.9, 168.3 дахь заалт	Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сургийг эрүүлжүүлэх	Эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо	20.0 саяас доошгүй	8.0 Улсын төсөв	ХХААЯ
4.6	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт	Газар тариалангийн техник, тоног төхөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх	Техник, тоног төхөрөмжийг шинэчлэх ажлын явц, хувиар	75.0	10.0 Гадаад эх үүсвэр	ХХААЯ
4.7	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт, “Чацаргана” Үндэсний хөтөлбөр, ҮХЦБ- ын 5.2.1.4.5 дахь зорилт	Чихрийн манжин тариалж, элсэн чихэр үйлдвэрлэх, чацаргана болон бусад жимсний тариалалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХХААЯ



**Зорилт 5.Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.**

5.1	ЗГҮАХХАХТ-ний 99.1 дэх заалт	Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100.0	14.0 Хувийн хэвшил, Гадаад эх үүсвэр	АҮЯ, УУЯ
5.2	ЗГҮАХХАХТ-ний 49.3 дахь заалт	Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	АҮЯ, УУЯ
5.3	ЗГҮАХХАХТ-ний 103 дахь заалт	Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	УУЯ, АҮЯ
5.4	ЗГҮАХХАХТ-ний 30.2 дахь заалт	Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	Нийт үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар	20.0	30.0 Хөгжлийн банк	АҮЯ, СЯ
5.5	ЗГҮАХХАХТ-ний 68.1, 69.3 дахь заалт	Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох	Арьс ширийг дотоодод боловсруулах хувь	60.0	80.0 Хөгжлийн банк	АҮЯ



5.6	ЗГҮАХХАХТ-ний 76 дахь заалт	Хоногт 2-5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлттэй төвүүдийг байгуулах	Байгуулах хөргөлттэй төвийн тоо	50	7.0 Гадаад эх үүсвэр	ХХААЯ АУЯ, Эрчим хүчний яам /цаашид "ЭХЯ" гэх/, УУЯ, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал, жуулчлалын яам /цаашид БОНХАЖЯ гэх/
5.7	ЗГҮАХХУАТ-ний 103.1 дэх заалт	Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	
5.8	ЗГҮАХХУАТ-ний 67.10 дахь заалт	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	ЭХЯ, УУЯ
5.9	ЗГҮАХХУАТ-ний 60.1 дэх заалт	Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, дэмжих үндэсний хөтөлбөрийг 2016 оны эхний хагас жилд багтаан боловсруулж батлуулах	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар	100.0	-	АУЯ, ГХЯ



<b>Зорилт 6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</b>						
6.1	ЗГҮАХХАХТ-ний 34.20 дахь заалт, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулах	Байгуулах төвийн тоо	5	0.6 Улсын төсөв 5.0 ТХХТ	АУЯ, АНЗДТГ
6.2	ЗГҮАХХАХТ-ний 35.9 дэх заалт, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.5.3 дахь заалт	Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгжийн тоо	80-аас доошгүй	-	АУЯ, СЯ
<b>Зорилт 7. Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.</b>						
7.1	ЗГҮАХХАХТ-ний 56.1, 56.2, 67.11, 67.12 дахь заалт	Чойрын дэд станцыг өргөтгөж, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станц, Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих ажлын бэлтгэлийг хангах	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100.0	5.0 ТХХТ	ЭХЯ, АУЯ

7.2	ЗГҮАХХАХТ-ний 64.1, 64.2, 64.3 дахь заалт	“ДЦС-5”-барилгын ажил, Сонгино дэд станц хүртэлх 220 кВ- ын ЦДАШ-ын барилга урсралтын ажлыг эхлүүлж, дулаан дамжуулах магистраль шугамын зураг, төслийг боловруулах	Барилгын ажлын явц, хувиар	10.0	150.0 сая ам.доллар ТХХТ  5.5 Гадаад эх үүсвэр	ЭХЯ, АҮЯ
7.3	ЗГҮАХХАХТ-ний 65.1, 67.2, 67.3, 67.5, 67.6 дахь заалт	Бүс нутгийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах хүрээнд Баруун болон Дорнод бүсийн ДЦС, Тавантолгой, Багануур, Тэлмэн, Баянтээгийн ДЦС-уудын барилгын ажлыг эхлүүлэх	Концессийн гэрээ байгуулах ажлын явц, хувиар	100.0	250.0 сая ам.доллар ТХХТ	ЭХЯ, АҮЯ
			Барилгын ажлын явц, хувиар	10.0		
7.4	ЗГҮАХХАХТ-ний 67.8 дахь заалт	Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт- аар нэмэгдүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	100.0	42.0 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	ЭХЯ
7.5	ЗГҮАХХАХТ-ний 67.10 дахь заалт	Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Хүчин чадлын нэмэгдэх хэмжээ	2 дахин	-	ЭХЯ, УУЯ

7.6	3ГҮАХХАХТ-ний 66.4 дэх заалт	Улаанбаатар хотын захын хорооллын 35/6 кв-ын дэд станцуудын хүчдэлийг 35/10 кв-д шилжүүлж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэн, 6-35 кв-ын кабель, шугамыг өргөтгөж, шинэчлэх	Барилгын явц, хувиар	100.0	0.8 Улсын төсөв	ЭХЯ
7.7	ЭЗХГАХХ-ийн 12.1 дэх заалт	Түлш, эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмын дагуу бодит өртгийн тооцоонд үндэслэн зохицуулалт хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Эрчим хүчний зохицуулах хороо
7.8	3ГҮАХХАХТ-ний 132.2 дахь заалт	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих	Барилгын ажлын явц, хувиар	50	-	ЭХЯ
7.9	3ГҮАХХАХТ-ний 225 дахь заалт	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх ажлын явц	100.0	-	ЭХЯ
7.10	3ГҮАХХАХТ-ний 225.1, "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр"-ийн 4.2.6 дахь заалт	Эгийн голын усан цахилгаан станц, түүний дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн ажлын явц	100.0	-	ЭХЯ

7.11	ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт	БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	ЭХЯ, ГХЯ
<b>Зорилт 8. Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.</b>						
8.1	ҮХЦБ-ын 5.3.1.7 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 220.2 дахь заалт	Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх төслийг эхлүүлэх	Бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	2.1 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	Зам тээврийн яам /цаашид “ЗТЯ” гэх/
8.2	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр /цаашид “ШББДХЗ” гэх/ ийн 4.4.2.10 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 112 дахь заалт	Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулах	Ярант- Ховд-Өлгий- Улаанбайшинт чиглэлийн замын урт, км	189.7	37.0 Улсын төсөв	ЗТЯ
8.3	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, “ШББДХЗ”-ийн 4.4.2.10 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 108.1, 108.4 108.8, 108.11 дэх заалт	Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох	Ховд, Увс, Баян- Өлгий, Говь- Алтай, Завхан аймгуудын чиглэлд баригдах замын урт, км	483	367.0 ТХХТ	ЗТЯ, АУЯ



8.4	ҮХЦБ-ын 5.3.1.3 дахь зорилт	Улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	Засвар, арчлалт хийгдэх авто замын сүлжээний урт, мян.км	12.7	18.0 Улсын төсөв	ЗТЯ
8.5	ҮХЦБ-ын 5.3.1, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого /цаашид "ТТЗТТББ" гэх/-ын 3.2.2, 3.2.4 дэх заалт, ЗГУАХХАХТ-ний 107.1 дэх заалт	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	Тавантолгой-Сайншанд чиглэлийн /435 км/	10.0	600.0 сая ам.доллар ТХХТ	ЗТЯ, АУЯ
			Сайншанд-Баруун урт-Хөөт чиглэлийн /430км/			
8.6	ҮХЦБ-ын 5.3.1.4 дэх зорилт, ЗГУАХХАХТ-ний 120.3 дахь заалт	Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	10.0	131.0 сая ам.доллар ТХХТ	ЗТЯ, АУЯ
			Барилгын ажлын явц, хувиар			
8.7	ЗГУАХХАХТ-ний 107.2 дахь заалт	Мандал-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтэц барих төслийг эхлүүлэх	Бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	26.6 сая ам.доллар Гадаад эх Үүсвэр	ЗТЯ
			Барилгын ажлын явц, хувиар			
8.8	"Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын 6.1.4 дэх заалт	Даланзадгад, Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	10.0	6.0 ТХХТ	ЗТЯ, АУЯ

8.9	ЗГҮАХХАХТ-ний 108.29 дэх заалт	Ховдоос Завханы чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай замыг барих асуудлыг судалж шийдвэрлэх	Бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	-	ЗТЯ
<b>Зорилт 9.Геологи, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>						
9.1	ҮХЦБ-ын 5.2.1.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 38.1 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	40.0	10.0 Улсын төсөв	УУЯ
9.2	ЗГҮАХХАХТ-ний 100.1, 100.2 дахь заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.5.7 дахь заалт	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	50.0	19.0 ТХХТ	УУЯ, АҮЯ
9.3	ТЭСББ-ын 3.3.3 дахь заалт	Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх	Ашиглалтад оруулах ордын тоо	25.0-аас доошгүй	-	УУЯ



9.4	ЗГҮАХ-ийн 40.12 дахь заалт	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх	Шинээр мөрдүүлэх үндэсний стандартын тоо	9	УУЯ, Стандартчилал хэмжил зүйн газар /цаашид "СХЗГ" гэх/, БОНХАЖЯ
			Шинээр нэвтрүүлэх олон улсын стандартын тоо		
9.5	ЗГҮАХХҮАТ-ний 60.1 дэх заалт	Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт-хийлгүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	БОНХАЖЯ, УУЯ
<b>Зорилт 10.Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.</b>					
10.1	ЗГҮАХХАХТ-ний 202.4 дэх заалт	Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн орчныг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /цаашид "БСШУЯ" гэх/
10.2	ЗГҮАХХАХТ-ний 202.4 дэх заалт	"Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө"-ний III үе шатыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	БСШУЯ

10.3	ЗГҮАХХАХТ-ний 283.3 дахь заалт	Монгол Улсын насанд хүрсэн иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч нарт цахим гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэх	Цахим гарын үсэг олгох ажлын явц, хувиар	50.0	-	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /цаашид "МТШХХГ" гэх/
<b>ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b>						
<b>Зорилт 11.Хүн амын нутагшилт, суурьшил, бус нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.</b>						
11.1	ЗГҮАХХАХТ-ний 115.5 дахь заалт	Төв аймгийн Хөшигийн хөндийн шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тоо  Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоо	1  1	0.3 Улсын төсөв	Барилга, хот байгуулал- тын яам /цаашид "БХБЯ", ЗТЯ
11.2	ЗГҮАХХАХТ-ний 130.2 дахь заалт	Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх талбайн хэмжээ, мянган га	48.5	2.4 Улсын төсөв	БХБЯ





11.3	ҮХЦБ-ын 5.3.5.3 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 3.7 дахь заалт	Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан түрээсийн орон сууцныг барьж ашиглалтад оруулах	Ашиглалтад орох орон сууцны тоо	1300	90.0 ТХХТ	БХБЯ, АҮЯ
11.4	ҮХЦБ-ын 5.3.5.3 дахь зорилт, ШББДХЗХХУАТ-ний 4.4.2.1. ЗГҮАХХАХТ-ний 127.2 дахь заалт	Аймаг, нийслэлийн ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээг үе шаттай шинэчлэх	Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх аймгийн тоо Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх аймгийн тоо	5 1	15.7 Хөгжлийн банк Гадаад эх үүсвэр	БХБЯ, АНЗДТГ
11.5	ЗГҮАХХАХТ-ний 267.4 дэх заалт	Газар хөдлөлтийн эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шаттай хэрэгжүүлж дуусгах	Бичил мужлалын зураг хийгдэж дуусах аймгийн тоо	12	0.9 Улсын төсөв	БХБЯ, БСШУЯ, АЗДТГ
<b>Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.</b>						
12.1	Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, техно-логийн парк байгуулах ажлыг эхлүүлэх	Байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	10	40.0 ТХХТ	АҮЯ, ХХААЯ

12.2	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 3.1.6 дахь заалт	Малчдыг нийгмийн даатгалд хамрагдах, малаа даатгуулах сонирхлын хөшүүргийг бий болгох	Нийгмийн даатгалд хамрагдах малчдын тооны өсөлт, хувиар	10.0	-	XXААЯ, ХАХНХЯ, АНЗДТГ
				10.0	-	
12.3	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2.3.1 дэх заалт	Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ХАА-н биржийн арилжаан дахь оролцоог нэмэгдүүлэх	ХАА-н биржийн арилжаанд оролцох малчдын тооны өсөлт, хувиар	15.0-аас доошгүй	-	XXААЯ, “Хөдөө аж ахуйн бирж”ХК
12.4	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт	Хүлэмжийн аж ахуйн тоо, хэмжээг нэмэгдүүлж, таримлын нэр төрлийг олшруулах	Шинээр байгуулах зун, өвлийн хүлэмжийн талбайн хэмжээ, мян.м <sup>2</sup>	100	-	XXААЯ
				2000	-	
12.5	ЗГҮАХХАХТ-ний 141.4 дэх заалт	Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох	Шилэн кабельд холбогдох сумын тоо	2	-	МТШХХГ



12.6	3ГҮАХХҮАТ-ний 34.2, 146.5 дахь заалт	Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХХААЯ
12.7	3ГҮАХХҮАТ-ний 72.6, 240.2 дахь заалт	Бэлчээрийн менажментийг сайжруулах, бэлчээр сэргээх, малын тэжээл бэлтгэх иргэдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХХААЯ
12.8	ҮХЦБ-ын 5.3.2 дахь заалт 3ГҮАХХҮАТ-ний 100 дахь заалт	Эрчим хүч, авто бензин, дизелийн тулшний үнийг Монгол Улсын хэмжээнд ижил байх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	АУЯ, ЭХЯ, УУЯ
<b>Зорилт 13. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.</b>						
13.1	3ГҮАХХҮАТ-ний 79.1 дэх заалт	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Боловсруулах эрх зүйн баримт бичгийн төслийн тоо	5-аас доошгүй	-	БОНХАЖЯ

13.2	ЗГҮАХХҮАТ-ний 229.1 дэх заалт	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхийг эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах	Байгууламжийн тоо	1	300.0 ТХХТ	БОНХАЖА, АҮЯ
13.3	ЗГҮАХХҮАТ-ний 230.2 дахь заалт	Бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах	Байгуулах хөв цөөрмийн тоо	3	0.45 Орон нутгийн төсөв	БОНХАЖА, ХХААЯ, АНЗДТГ
			Хамгаалалт хийх булаг шандны тоо	120-иос доошгүй	0.24 Орон нутгийн төсөв	БОНХАЖА, АНЗДТГ
13.4	ЗГҮАХХҮАТ-ний 232.3 дахь заалт	Улсын тусгай хамгаалалттай болон орон нутгийн тусгай хэрэгцээт газрын ашиглалтыг зохистой түвшинд байлгах зорилгоор эрх зүйн орчныг сайжруулах	Тусгай хамгаалалтад авах талбайн хэмжээ, га	600.0	0.01 Улсын төсөв	БОНХАЖА
13.5	“Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.2 дахь заалт	Туул усан цогцолбор, Орхоны шинэ нуур, Шүрэнгийн УЦС-ын ажлын зураг төслийг боловсруулах	Зураг төслийн тоо	3	9.4 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	БОНХАЖА, ЭХЯ
13.6	“Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.3, 3.3.4, 3.3.5 дахь заалт	Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул, судалгаа хийх	Хайгуул судалгааны ажлын тоо	3	0.6 Улсын төсөв	БОНХАЖА

13.7	ЗГҮАХХҮАТ-ний 34 дэх заалт	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц, үр дүнтэй арга хэмжээ авах	Нарийн ширхэгт тоосонцор (PM 2.5), хүхэрлэг хий (SO2)-н агууламжийн бууралт, хувиар	20-иос доошгүй	-	БОНХАЖЯ, НЗДТГ
13.8	ЗГҮАХХҮАТ-ний 79.3, 79.5 дахь заалт	Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих	Жуулчдын тоон өсөлт, хувиар	20-иос доошгүй	-	БОНХАЖЯ
<b>Зорилт 14. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчийн бие бялдрын тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлнэ.</b>						
14.1	Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр /цаашид "ГХЧБҮХ" гэх/-ийн 3.3.1, 3.3.2, 3.3.4 дэх зорилт	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Боловсруулах хуулийн төслийн тоо	1	-	Шадар сайдын ажлын алба, Хууль зүйн яам /цаашид "ХЗЯ" гэх/
			Боловсронгуй болгох хуулийн төслийн тоо	1		
14.2	ГХЧБҮХ-ийн 3.5.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 264.8 дахь заалт	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах	Ашиглалтад орох аврах, гал унтраах ангийн тоо	5	2.3 Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/

14.3	ГХЧБҮХ-ийн 3.5.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 264.8 дахь заалт	Онцгой байдлын албаны гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	11.0 Гадаад эх үүсвэр	ОБЕГ
14.4	Г а м ш г а а с хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын 2.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 264.7 дахь заалт	Мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчдын дайчилгааны дараах бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ОБЕГ Эрүүл мэнд, спортын яам /цаашид "ЭМСЯ" гэх/
<b>ДӨРӨВ.ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО</b>						
<b>Зорилт 15.Хүүхэд, сурагч, оюутан нэг бүрийг хөгжүүлж, багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.</b>						
15.1	ЗГҮАХХАХТ-ний 186.1 дэх заалт	Ерөнхий боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Шинээр нэмэгдэх суудлын тоо	10,000-аас доошгүй	25.0 Улсын төсөв	БСШУЯ
15.2	ЗГҮАХХАХТ-ний 187.9 дэх заалт	Ерөнхий боловсролын сургуулийн I-V болон X-XII ангийн сурах бичгийн агуулга, стандартыг шинэчилж, нөхөн хангалт хийх	I-V, X-XII ангийн сурах бичгийн нэр төрлийн тоо	49	2.0 Улсын төсөв	БСШУЯ
15.3	ЗГҮАХХАХТ-ний 201.1, 201.2, 201.3 дахь заалт	Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	Хөнгөлөлт үзүүлэх оюутны тоо	3000 хүртэл	3.0 Улсын төсөв	БСШУЯ



15.4	ЗГҮАХХАХТ -ний 204.2 дахь заалт	Инженер, технологийн дээд боловсрол төслийн хүрээнд судлаач, оюутныг сургалтад хамруулах	Зэргийн бус хөтөлбөрт шинээр элсүүлэх оюутны тоо	67	9.3 Гадаад эх үүсвэр	БСШУЯ
				40		
				40		
15.5	ЗГҮАХХАХТ -ний 200 дахь заалт	Багануур дахь их сургуулиудын хотхоны дэд бүтэц, барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар	5.0	5.0 ТХХТ	БСШУЯ
15.6	ЗГҮАХХАХТ -ний 201.1, 201.2, 201.3 дахь заалт	"Дээд боловсролын шинэчлэл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	17.0 Гадаад эх үүсвэр	БСШУЯ
15.7	ЗГҮАХХАХТ -ний 204.1, 204.2 дахь заалт	Дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан суралцуулж, өрсөлдөх чадвартай монгол хүнийг хөгжүүлэх	Суралцуулах оюутны тоо	120	11.5 Улсын төсөв	БСШУЯ

15.8	ЗГҮАХХАХТ-ний 205.3 дахь заалт	Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчинд үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.5 Гадаад эх үүсвэр	БСШУЯ
15.9	ЗГҮАХХАХТ-ний 91 дэх заалт	Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	12.8 Гадаад эх үүсвэр	БСШУЯ
15.10	ЗГҮАХХАХТ-ний 187.8, 187.9 дэх заалт	Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах зорилгоор “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдах сургуулийн тоо	125	1.0 Улсын төсөв 4.0 Гадаад эх үүсвэр	БСШУЯ
15.11	ЗГҮАХХАХТ-ний 193.1 дэх заалт	Боловсролын байгууллагын мэдээллийн нэгдсэн сан бүхий “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг боловсруулж, нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	1.5 Улсын төсөв, Гадаад эх үүсвэр	БСШУЯ
15.12	ЗГҮАХХАХТ-ний 300 дахь заалт	Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогыг шинэчилж, залуучуудын асуудлыг гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, хүн амын хөгжлийн бодлоготой уялдуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХАХНХЯ





Зорилт 16.Эх орондоо эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хийх боломжийг бүрдүүлнэ.						
16.1	ЗГҮАХХАХТ-ний 165.2, 168.1, 174.1 дэх заалт	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлж, ажиллагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМСЯ
16.2	ЗГҮАХХАХТ-ний 169.1 дэх заалт	Эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийг сайжруулж, шаардлагатай эмнэлтийн барилгуудад их засвар хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	14.0 Улсын төсөв	ЭМСЯ, СЯ
16.3	ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт	Оношилгоо, эмчилгээний стандартыг үе шатайгаар шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	Шинээр боловсруулах стандарт, зааврын төслийн тоо	10	-	ЭМСЯ
16.4	ЗГҮАХХАХТ-ний 176.1 дэх заалт	Алслагдсан сумдыг телемедицины үндэсний сүлжээний дэд бүтцэд холбох	Телемедицины сүлжээнд холбогдох сумын тоо	8	0.5 Улсын төсөв	ЭМСЯ
16.5	ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт	Сонгинохайрхан дүүрэгт загвар нэгдсэн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх	Барилга угсралтын ажлын явц, хувиар	10.0	6.6 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	ЭМСЯ
16.6	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.4.1.3, Хүнсний тухай хууль 9.1.1, 9.1.2 дахь заалт	Хүн амын хоол тэжээл, өрхийн хүнсний хэрэглээ, хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх үндэсний судалгааг зохион явуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.3 Гадаад эх үүсвэр	ЭМСЯ

16.7	ҮХЦБ-ын 4.5.2 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 167.5 дахь заалт	Эмийн чанар, аюулгүй байдлын цахим мэдээллийн тогтолцооны системийг нэвтрүүлэх	Нэвтрүүлэх программ хангамжийн тоо	2	0.5 Улсын төсөв	ЭМСЯ
16.8	ЗГҮАХХАХТ-ний 184.1 дэх заалт	Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМСЯ, ХАХНХЯ
16.9	ҮХЦБ-ын 4.5.1 дэх зорилт	Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хууль гаргаж, төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМСЯ, ХАХНХЯ
<b>Зорилт 17. Соёл, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлж, биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох бодлого баримтална.</b>						
17.1	“Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ын 3.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 214 дэх заалт	Бүх нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн, наадмын зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМСЯ



17.2	ЗГҮАХХАХТ-ний 138.1, 140.1 дэх заалт	Хүүхэд, залуучуудад зориулсан спорт үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах	Шинээр ашиглалтад орох спорт цогцолборын суудлын тоо	5000	31.5 Улсын төсөв	ЭМСЯ
				1	2.0 Улсын төсөв	
17.3	"Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого"-ын 2.2.2 дахь заалт	Төр, төрийн бус байгуулага, аж ахуйн нэгж, байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн бүх шатны магадлан итгэмжлэлийг эхлүүлэх	Шинээр ашиглалтад орох усан бассейны тоо	1		ЭМСЯ
				100.0	-	
17.4	"Төрөөс соёлын талаар баримтлах бодлого"-ын 4.3 дахь заалт	Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо	1	-	БСШУЯ
<b>Зорилт 18. Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг эрчимжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.</b>						
18.1	ҮХЦБ-ын 4.8.2.1 дэх зорилт	Ажил олгогчидтой хамтран хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн хэрэгцээг тодорхойлох, тэдгээрт нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар олгох үйлдвэрлэл дээрх сургалтыг өргөжүүлэх	Боловсронгүй болгох хуулийн төслийн тоо	1		ХЯ
				2500	-	

18.2	ҮХЦБ-ын 4.8.3 дахь зорилт	Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын ажлын байраар хангахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	6.0 Хөдөл- мөр эрхлэл- тийг дэмжих сан/ цаашид "ХЭДС" гэх/	ХЯ
18.3	"Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88, 181 дүгээр Конвенци	Ажилд зуучлах, зөвлөх бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог сайжруулах	Ажлын байранд зуучлагдсан иргэдээс байнгын ажлын байртай болох иргэдийн хувь	60.0 – аас доошгүй	1.0 ХЭДС	ХЯ
18.4	ЗҮГАХХАХТ-ний 20.1 дэх заалт	Хөдөлмөрийн хөлсийг цагаар олгох зохистой хэлбэрийг судалж, цалингийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан индексжүүлж нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Боловсронгүй болгох журмын төслийн тоо Сургалтын хөтөлбөрийн тоо	1 3	-	ХЯ

18.5	ЗГҮАХХАХТ-ний 20.1 дэх заалт	Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг улсын төсвийн боломжтой уялдуулан судалж, шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр, хувиар	100.0	-	ХЯ, ХАХНХЯ, СЯ
18.6	Хөдөлмөр, нийгмийн зөвшилтийн гурван талтын 2015-2016 оны хэлэлцээрийн 3.2 дэхь заалт	Хувь хүний албан татвар тооцох орлогоос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээгээр хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Боловруулах хуулийн төслийн тоо	1	-	ХЯ, СЯ
18.7	ҮХЦБ-ын 4.8.2 дэхь зорилт	Гадаадаас ажиллах хүч авах тогтолцоог боловсронгүй болгож, ажиллах хүчинд тавигдах шаардлагыг сайжруулж, зуучлалын үйл ажиллагааг эрхлэх байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах	Боловсронгүй болгох хуулийн төслийн тоо	1	-	ХЯ, СЯ, ХЗЯ
18.8	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.21 дэх заалт	Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Боловруулах бодлогын баримт бичгийн төслийн тоо  Ур чадварын түвшинг тодорхойлох мэргэжлийн тоо	1   10- аас доошгүй	-	ХЯ, БСШУЯ

18.9	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.3 дахь заалт	Мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх чиглэлийг тогтоох замаар төрөлжүүлэх бодлогыг боловсруулах	Төрөлжүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо	37	-	ХЯ
<b>Зорилт 19. Нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.</b>						
19.1	ЗҮГАХХАХТ-ний 161.3 дахь заалт	Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сүлжээнд сумдын мэдээллийг холбох үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх	Нэгдсэн сүлжээнд холбох ажлын явц, хувиар	80.0	-	ХАХНХЯ
19.2	ҮХЦБ-ын 4.3.1 дэх зорилт	"Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн шаталсан хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХАХНХЯ, Хүүхдийн төлөө үндэсний газар /цаашид "ХТҮГ" гэх/
19.3	Засгийн газрын 2011 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллын стратегийн төлөвлөгөөний 6 дахь зорилт	Хүүхэд хамгааллын тусламжийн цогц, шуурхай үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагаас шууд яаралтай тусламж үзүүлэх, хариу арга хэмжээ авах	Дуудлагын шийдвэрлэлтийн явц, хувиар  Олон нийтийн мэдээллийн хэрэгс-лээр сурталчлах ажлын явц, хувиар	100.0  100.0	0.2 Улсын төсөв	ХАХНХЯ, ХТҮГ



19.4	ЗГҮАХХАХТ-ний 157.1 дэх заалт	Өндөр настны асрамжийн төв байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХАХНХЯ
19.5	ЗГҮАХХАХТ-ний 155.1 дэх заалт	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд ахмадуудыг зуучлан хамруулах, богиносгосон цагаар ажиллах боломжийг бүрдүүлэх	Бий болох үндэсний сүлжээний тоо	1	-	ХАХНХЯ, ХЯ
19.6	ЗГҮАХХАХТ-ний 161.4 дэх заалт	Өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн өрхийн амьжиргааны түвшнээр ангилсан шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх	Нэвтрүүлэх шинэ төрлийн үйлчилгээний тоо	2-3	-	ХАХНХЯ
19.7	ҮХЦБ-ын 4.3.1, 4.3.3 дахь зорилт	“Олон хүүхэд төрүүлсэн эх, олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо	1	-	ХАХНХЯ
19.8	ҮХЦБ-ын 4.3.2 дахь зорилт	Ахмадуудаа халамжлах, ач санах хууль боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХАХНХЯ
19.9	ҮХЦБ-ын 4.8 дахь зорилт	Нөхцөлт мөнгөн шилжүүлгийн зарчмыг нийгмийн бодлого, тэтгэвэр тэтгэмж, халамжийн бодлогод тусган хэрэгжүүлэх талаар иж бүрэн арга хэмжээ авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХАХНХЯ

**ТАВ.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО**

**Зорилт 20.Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн бодлогыг дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.**

20.1	ЗГҮАХХАХТ-ний, 30.6, 30.7, 34.9 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 196 дахь заалт	Ял шийтгүүлсэн этгээдийг ажлын байраар хангах мэргэжлийн сургалтад хамруулах, улмаар суллагдан гарахад ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх	Ашиглалтад оруулах үйлдвэрийн төрөл Ажлын байраар хангах хувь	4	0.8 Улсын төсөв	ХЗЯ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /цаашид "ШШГЕГ" гэх/
				60		
				50		
20.2	ЗГҮАХХАХТ-ний 259.6 дахь заалт	Гадаад орнуудын архивт хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх соёлтой холбогдох баримтыг илрүүлэх, тэдгээрийг хуулбарлах, худалдан авах замаар сан хөмрөгийг баяжуулах	Сан хөмрөгийг баяжуулах ажлын явц, хувиар	20	-	ХЗЯ, Архивийн ерөнхий газар
20.3	ҮХЦБ-ын 7.2.5 дахь зорилт	Аймгуудын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах	Хамрагдах аймгийн тоо	13	15.0 Гадаад эх үүсвэр	ХЗЯ, УБЕГ
20.4	ҮХЦБ-ын 7.2 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 17.1 дэх заалт	Төрөөс худалдан авах ажиллагааны талаар баримтлах бодлогын цогц баримт бичиг боловсруулах, эрх зүйн орчныг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ, Худалдан авах ажиллагааны газар



20.5	ЗГҮАХХАХТ-ний 297.1 дэх заалт	Төрийн аудитын чанарыг сайжруулж, үйлчилгээг ил тод, хүртэмжтэй болгох	Цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар	100.0	1.0 Улсын төсөв	Үндэсний аудитын газар
20.6	ҮХЦБ-ын 5.3.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 283 дахь заалт	Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор нээлттэй ухаалаг төрийн удирдлагын системийг нэвтрүүлэх	Удирдлагын систем суурилагдах дүүргийн тоо	6	1.2 Гадаад эх үүсвэр	МТШХХГ
20.7	ҮХЦБ-ын 7.3. дахь заалт, ЗГҮАХХАХТ- ний 302.1, 302.2 дахь заалт	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны удирдлагын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож, давхардлыг арилгах, Бодлогын нэгдмэл чанарыг хангах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ХЗЯ
20.8	ЗГҮАХХАХТ-ний 17 дахь заалт	Төрийн захиалгаар гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн төлбөрийг тухайн санхүүгийн жилд багтаан гүйцэтгэж байх эрх зүйн орчныг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ

20.9	ЗГҮАХХАХТ-ний 17, 27.1 дахь заалт	Төсөв, хөрөнгө оруулалтын төвлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ
20.10	ЗГҮАХХАХТ-ний 15.2, 169.2, 264.5 дахь заалт	Архивын шинэ барилга, Төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмжийн зардал, түүнчлэн шинээр баригдаж байгаа хорих ангийн барилгын санхүүжилтийг шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗЯ, ШШГЕГ
20.11	ЗГҮАХХАХТ-ний 15.2, 306.1 дэх заалт	Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг шийдвэрлэх 2016 оны төсөвт тусгах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗЯ
20.12	ЗГҮАХХАХТ-ний 291.2, 310.1 дэх заалт	Гэрч, хохирогчийг хамгаалах, Тахарын албыг бэхжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт гэсэн заалтыг 2016-2018 оны төсвүүдэд тусгайлан тусгах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗЯ



Зорилт 21.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт, идэвхитэй гадаад бодлого явуулна.						
21.1	ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт	ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцах бодлого баримталж, стратегийн түншлэлийн харилцааг бататган бэхжүүлэх	Дээд түвшинд хийгдэх уулзалтын тоо	2	-	ГХЯ
21.2	ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт	Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах	Дэмжихээ илэрхийлэх улсын тоо	2-оос доошгүй	-	ГХЯ
21.3	ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт	Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах	Дэмжихээ илэрхийлэх улсын тоо	2-оос доошгүй	-	ГХЯ
21.4	ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт	Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг 2016 онд Улаанбаатар хотод зохион байгуулах	Дэмжин оролцох улсын тоо	51	50.0 Улсын төсөв	ГХЯ
21.5	ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 259 дэх заалт	"Монгол Улсыг гадаад сурталчлах хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх	Хэрэгжих хөтөлбөрийн тоо	1	-	ГХЯ, БОНХАЖЯ



21.6	ҮХЦБ-ын 7.5.3 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 258 дахь заалт	Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим виз олгох ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааг эхлүүлэх дипломат төлөөлөгчийн газрын тоо	4	0.5 Улсын төсөв	ГХЯ
<b>Зорилт 22.Батлан хамгаалахын чадавхийг нэмэгдүүлж, улс орны бүтээн байгуулалтад оролцох боломжийг дээшлүүлнэ.</b>						
22.1	ЗГҮАХХАХТ-ний 248, 250.2, 250.3 дахь заалт	Батлан хамгаалах, энхийг сахиулах үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	6.5 Улсын төсөв	Батлан хамгаалах яам /цаашид "БХЯ" гэх
22.2	ЗГҮАХХАХТ-ний 251.3 дахь заалт	"Цэргийн авто болон тусгай зориулалтын техникийн парк шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх хүрээнд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний улс орны бүтээн байгуулалтад оролцох чадавхийг дээшлүүлэх	Авто техникийн бэлэн байдлын түвшин дээшлэх хувь	100.0	1.2 Улсын төсөв	БХЯ
22.3	ЗГҮАХХАХТ-ний 247 дахь заалт	Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, улсын хилийг хамтран шалгасан протоколын дагуу Монгол-Оросын хилийн багана, тэмдгийг засварлах	Засварлах хилийн тэмдгийн тоо	643-аас доошгүй	-	ХЗЯ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг биелүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/цөмийн зэвсэгтэй таван улс, “Цөмийн зэвсэггүй бүсүүд ба Монгол Улс”-ын бага хурал, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн болон бүс нутгийн холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн болон бүс нутгийн баримт бичгүүдэд Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын статус нь бүс нутгийн тогтвортой байдал болон итгэлцлийг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл болж байгааг тусгаж байх, улс төрийн хоёр талын баримт бичгүүдэд мөн санааг тусгаж дэмжүүлж байх, уг статусын ач холбогдлыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах арга хэмжээг авч байх;

2/Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай статусыг цаашид урагшлуулан бэхжүүлэхдээ бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдалтай холбох, Зүүн хойд Азид аюулгүй байдлын яриа хэлэлцээ явуулах тухай Монгол Улсын санаачилгын нэг чухал хүчин зүйл болгож ажиллах;

3/Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протокол болон Цөмийн бага хэмжээний шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох;

4/хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улстай цөмийн салбарт хамтран ажиллахдаа хил залгаа нутагт байгаа цөмийн байгууламжийн талаар мэдээлэл авч байх;

5/Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа чичирхийллийн, нил авианы болон радионуклидын станцуудын мэдээ,



мэдээллийг тус улсын хавийн орчин, газар хөдлөлтийн давтамж, ажиглагдаж байгаа хандлагыг судлах, цаашид гарч болзошгүй гэнэтийн аюулаас сэргийлэх, хөрсөн доор гарч байгаа физик бодит өөрчлөлт, түүний үр дагавар зэргийг сонирхсон бусад улс, байгууллагатай хамтран судалж ажиллах.

2.Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статус, энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу хийж гүйцэтгэж байгаа ажлын талаар Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд жил бүр мэдээлсүгэй.

3.Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статус, тус улсаас бусад улс, олон улсын байгууллагатай цөмийн энергийн салбарын үндэсний аюулгүй байдлыг хөндсөн төрийн дотоод, гадаад бодлогын зарчмын асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус зөвлөлөөс чиглэл авсны үндсэн дээр шийдвэрлэсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

### **Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” /цаашид “Бодлого” гэх/ баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги хөтөлбөрийг таван жилээр төлөвлөж, холбогдох төлөвлөгөө, төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;



2/бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/энэ тогтоолын 2 дахь заалтын 1-д заасан стратеги хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;

4/дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах.

3.Бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж. Батсуурь/-нд даалгасугай.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

## **3.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
62 дугаар тогтоолын хавсралт

### **ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО**

#### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Аж үйлдвэрийн салбар нь төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн, дэвшилтэт техник, технологи, өндөр бүтээмж, өрсөлдөх чадвар бүхий экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл мөн.

1.2.Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлээс мэдлэг, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэн, бүтээмжийг дээшлүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн цогц зорилтыг тодорхойлоход чиглэнэ.

1.3.Уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад үйлдвэрийн салбарууд аж үйлдвэрийн бодлогод хамаарна.

1.4.Энэхүү бодлого нь Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах үндсэн баримт бичиг байх бөгөөд бусад салбарын бодлоготой харилцан уялдсан байна.



### **Хоёр.Бодлогын зарчим**

2.1.Төрөөс аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1.хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих;

2.1.2.экспортын чиг баримжаатай, импортыг орлох, өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

2.1.3.дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

2.1.4.төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;

2.1.5.аж үйлдвэрийн салбарт оролцогч талуудын үйл ажиллагаанд тэгш байдал, шударга өрсөлдөөнийг дэмжих;

2.1.6.аж үйлдвэрийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварын байдалд судалгаа хийж, аж үйлдвэрийн бүтцийг нэмэгдүүлэх стратегийг баримтлах.

### **Гурав.Бодлогын зорилго**

3.1.Бодлогын зорилго нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино.

### **Дөрөв.Бодлогын зорилт, түүнийг хэрэгжүүлэх чиглэл**

4.1. Бодлогыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

4.1.1.аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.2.аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах;





4.1.3.аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх;

4.1.4.аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих;

4.1.5.дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих;

4.1.6.бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

4.1.7.аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.8.худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.

4.2.Бодлогын зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиглэлийг баримтална:

4.2.1.аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1.1.аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөө, зорилтот хөтөлбөрүүдийг олон улсын хөгжлийн жишигт нийцүүлэн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагатай уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх;

4.2.1.2.оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахыг бодлогоор дэмжих;

4.2.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд хамруулах тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх;

4.2.1.4.худалдааны эрх зүйн орчныг дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, хөгжүүлэх бодлоготой уялдуулан, нэг хаалганы тогтолцоог хөгжүүлж, тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэх;



4.2.1.5. үйлдвэрлэл эрхлэгчдэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.2.1.6. хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг бий болгож, тогтолцоог боловсронгуй болгох;

4.2.1.7. зээлийн батлан даалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх;

4.2.1.8. кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох;

4.2.1.9. аж үйлдвэрийн салбарт шаардлагатай судалгаа хөгжлийн ажлыг эрчимжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлийг бий болгох, технологийн түвшинг сайжруулах, аж үйлдвэрийн оюуны өмчийн патентыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан судалгааны тогтолцоог бүрдүүлэх, судалгааны төвийг байгуулж ажиллуулах;

4.2.1.10. төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан аж үйлдвэрийн мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгох;

4.2.1.11. дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг бий болгох;

4.2.1.12. генетик материал, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдгээрийг ашигласнаас бий болох үр ашгийг ил тод хуваарилахтай холбоотой эрх зүйн орчныг бий болгох;

4.2.1.13. аж үйлдвэрийн салбарт мэдээллийн технологи, харилцаа холбоо болон мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлж, аж үйлдвэрийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

4.2.2. Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах зорилтын хүрээнд:

4.2.2.1. экосистем, геополитик, хүн амын нутагшил, суурьшил, дэд бүтэц, ашигт малтмал, үндсэн түүхий эдийн нөөцөд үндэслэн аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлох;



4.2.2.2.“Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг боловсруулж, батлуулах;

4.2.2.3.аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох.

4.2.3.Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

4.2.3.1.бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоох;

4.2.3.2.хүнд, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх, кластерийн талаар баримтлах стратегийг боловсруулах;

4.2.3.3.хөдөө аж ахуй, уул уурхайн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар хөгжүүлэх;

4.2.3.4.түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоо, бараа бүтээгдэхүүнийг борлуулах тээвэр логистикийн сүлжээг кластерийн тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх;

4.2.3.5.кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор барих байршил, жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх;

4.2.3.6.газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулах.

4.2.4.Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, нийгэм, эдийн засгийн үр ашиг бүхий үндсэн материалын, машин, тоног төхөөрөмжийг угсрах, болон бусад боловсруулах, дахин боловсруулах бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих зорилтын хүрээнд:

4.2.4.1.аж үйлдвэрийн салбарт үзүүлэх санхүү, хөрөнгө оруулалтын тогтолцоог боловсронгуй болгох;

4.2.4.2.инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах болон бүтээлч аж үйлдвэрлэлийг тусгай сангаас дэмжих;



4.2.4.3.аж үйлдвэрийг дэмжих тусгай сангийн хөрөнгийг дотоод, гадаад эх үүсвэрээр нэмэгдүүлэх;

4.2.4.4.кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркад үйлдвэрлэл эрхлэгчдийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих;

4.2.4.5.хүнд аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, концессоор барьж байгуулах, хөрөнгө оруулалтыг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих.

4.2.5.Аж үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан, төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд:

4.2.5.1.аж үйлдвэрийн салбарт судалгаа хөгжлийн ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрөөс урамшуулах зохицуулалтыг бий болгох;

4.2.5.2.аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих, гадаад улс орнуудын технологийн дэвшлийг ашиглах, нутагшуулах замаар болон өөрийн орны нөөц, чадавх, онцлогт тулгуурлан хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

4.2.5.3.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.2.5.4.төр, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн дэвшилтэт технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх тогтолцоог дэмжих.

4.2.6.Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.2.6.1.үндэсний түүх, өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, мэдлэг, мэдээлэлд суурилсан бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурлан мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар хөгжүүлж, шинэ чадавхи, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;

4.2.6.2.соёлын статистикийг олон улсын байгууллагаас баталсан аргачлалын дагуу нэвтрүүлэх.



4.2.7.Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах зорилтын хүрээнд:

4.2.7.1.үйлдвэрийн удирдлага, инженер, техникийн ажилтныг өндөр технологи бүхий улсуудад үе шаттайгаар бэлтгэх, мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх тогтолцоог бий болгож, дотоодод бэлтгэх чадавхыг сайжруулах;

4.2.7.2.техникийн болон технологийн боловсролын чиглэл, төрлөөр мэргэжлийн зэрэг олгох, мэргэжлийн ур чадвартай уялдсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх;

4.2.7.3.гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх бүтээлч санал, санаачлагыг дэмжих, тэдний мэдлэг, туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

4.2.7.4.үйлдвэрлэл, технологийн инкубаторийг хөгжүүлэх замаар гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих;

4.2.7.5.ур чадварт суурилсан, ажлын байран дахь болон зайны сургалтаар мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

4.2.8.Худалдааны таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх зорилтын хүрээнд:

4.2.8.1.хоёр болон олон талт худалдааны харилцаа, бүс нутгийн интеграцид нэгдэн орохдоо дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;

4.2.8.2.худалдааны ерөнхий хэлэлцээр, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээр болон давхар татварын гэрээ, хэлэлцээрийг байгуулах замаар олон улсын болон бүс нутгийн худалдааны интеграцид идэвхтэй оролцож, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын болон хамтарсан үйлдвэрүүдийг байгуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, дэвшилтэт техник, технологи, шилдэг менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх;

4.2.8.3.түнш орнууд болон бүс нутгийн хэмжээнд байгуулах худалдааны хэлэлцээрт худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах арга хэмжээг тусгах замаар гадаад зах зээлд дотоодын үйлдвэрийн барааны нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх;

4.2.8.4.экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг худалдааны болон эдийн засгийн чөлөөт бүсэд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;



4.2.8.5.цахим сүлжээ ашиглан аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдах үйл ажиллагааг дотоодод болон олон улсад нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх;

4.2.8.6.иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг хамруулах ажлыг зохион байгуулалтаар хангах.

### **Тав.Бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

5.1.Бодлогыг дараах 3 үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1.I үе шат /2015-2020 он/: үндэсний үйлдвэрлэлийг хамгаалж, үндсэн түүхий эдийг дотооддоо боловсруулж, техник, технологийг нутагшуулан экспортыг дэмжих, импортыг орлох аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.2.II үе шат /2020-2025 он/: экспорт давамгайлсан аж үйлдвэрийн бүтцийг бий болгож өндөр технологи, машин, тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

5.1.3.III үе шат /2025-2030 он/: мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлж, үйлчилгээ болон технологийн экспортыг дэмжин хөгжүүлнэ.

### **Зургаа.Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

6.1.Хүн амын амьжиргааны түвшин сайжирч, үндэсний аюулгүй байдлын баталгаа нэмэгдэнэ.

6.2.Үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дотоодын хэрэгцээгээ хангасан экспортлогч орон болж, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

6.3.Боловсруулах болон үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 2014 оны түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.

6.4.Үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдаж, үйлдвэрийн кластер, логистикийн сүлжээ хөгжинө.

6.5.Судалгаа хөгжлийн боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж үндэсний баялгийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.



6.6.Аж үйлдвэрийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бий болж, экспортын зах зээл өргөжинө.

6.7.Үндэсний түүх, соёлын онцлогийг агуулсан, шинэ бүтээл, бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл хөгжсөнөөр эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэж, соёлын нөлөө олон улсад бэхэжсэн байна.

### **Долоо.Удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

7.1.Энэхүү бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал дахь аж үйлдвэрийн салбарын бүтцийн хөгжлийг дэмжих, бүтээмж, өрсөлдөх чадвар болон технологийн түвшнийг сайжруулах, байгаль орчинд ээлтэй техник, технологийг нэвтрүүлэхэд бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын болон бүс нутгийн зах зээлийн хандлагын судалгаанд тулгуурлан дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий, төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбооны тэгш оролцоог хангасан аж үйлдвэрийн Бодлогын зөвлөл ажиллана.

7.2.Бодлогын хэрэгжилтийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн оролцоотойгоор зохион байгуулна.

7.3.Бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

### **Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай**

Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:



1/“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”-ийг 2015 онд багтаан боловсруулж батлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хоёр жил тутам хийж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулж байх.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 32 дугаар тогтоол, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
63 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР  
БАРИМТЛАХ БОДЛОГО  
/2015-2030/**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар мөн.

1.2.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын зорилго нь улс орны өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангах, цаашид эрчим хүч экспортлогч орон болоход оршино.

1.3.Эрчим хүчний салбарын эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, анхдагч эрчим хүчний олборлолт, түлшний нөөц бүрдүүлэлт, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хангалтын үйл ажиллагаа, эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын баримт бичгийг үндэслэл болгоно.





#### 1.4. Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

1.4.1.Монгол Улс нь анхдагч эрчим хүчний хувьд баялаг нөөцтэй бөгөөд нүүрс, газрын тос, уран, сэргээгдэх эрчим хүчний тогтоогдсон нөөц болон шатдаг занар, байгалийн хийн баялаг ихтэй.

1.4.2.Монгол Улсын эрчим хүчний салбар нь газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран Баруун, Төв, Зүүн бүс болон Алтай-Улиастайн эрчим хүчний сүлжээ гэсэн дөрвөн хэсгээс бүрдэж байна.

1.4.3.Улсын хэмжээнд цахилгаан үйлдвэрлэлийн нийт суурилагдсан хүчин чадлын 85 хувийг нь нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх станц, 5 хувийг салхин парк, 7 хувийг дизель станц, 2 хувийг усан цахилгаан станц, 0.62 хувийг бага оврын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүрдүүлж, цахилгаан хангамжийн 80 хувийг дотоодод үйлдвэрлэж, импортоор 20 хувийг авч ашиглаж байна.

1.4.4.Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт төлөвлөгдсөн том чадлын эх үүсвэрийн төслүүд цаг хугацаандаа хэрэгжээгүйгээс системийн хэмжээнд суурилагдсан хүчин чадлын нөөц зохих түвшнээс багасаж, оргил ачааллын горимд ажиллах, системийн тогтворжилтыг хангах дотоодын эх үүсвэргүй байдал хэвээр байна. Импортын цахилгаан эрчим хүчний хэмжээ нийт хэрэглээний 20 хувьд хүрээд байна.

1.4.5.Цахилгаан, дулааны эрчим хүчний борлуулалтын үнэ бодит зардлаас доогуур тогтоогдож ирсэн нь эрчим хүчний салбарын үйлдвэрүүд санхүүгийн хувьд бие даан хөрөнгө оруулалт, их засвар, техник, технологийн шинэчлэлтээ зохих түвшинд хийж чадахгүй байна. Эрчим хүчний салбар 2014 онд 68 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай ажилласан байна.

1.4.6.Эрчим хүчний үнэ тариф доогуур, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй нь шинээр эхлэх том чадлын төслийн санхүүжилтийг босгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад сөргөөр нөлөөлж байна.

1.4.7.Ашиглалтад байгаа Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Дорнодын дулааны цахилгаан станцууд, дамжуулах, түгээх сүлжээний дийлэнх хувь нь 1960-1980 онд баригдсан бөгөөд салбарын хүрээнд насжилт өндөр тоног төхөөрөмжийн эзлэх хувь өндөр байна.

1.4.8.Улсын хэмжээнд цахилгаан станцуудын дотоод хэрэгцээ 14.4 хувь, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний алдагдал



13.7 хувь байгаа нь хөгжингүй орнуудын жишгээс 1.3-аас 1.7 дахин өндөр байна. Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн түвшинд хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Хоёр.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын алсын хараа, тэргүүлэх чиглэл, баримтлах тулгуур зарчим**

2.1.Алсын хараа нь улс орны эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил, эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, хувийн хэвшил, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлд суурилсан үр ашигтай, хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи бүхий, цахилгаан эрчим хүч экспортлогч орон болоход оршино.

2.2.Монгол Улсын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, хүрсэн түвшин, тулгамдаж байгаа асуудал, дэлхийн хөгжлийн чиг хандлагад үндэслэн “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ын тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна:

- 2.2.1.эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдал;
- 2.2.2.үр ашиг, бүтээмж;
- 2.2.3.байгаль орчны тогтвортой байдал, ногоон хөгжил.

2.3.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах зорилго, зорилтыг тодорхойлоход дараах тулгуур зарчмыг баримталж байна:

2.3.1.улс орны эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангасан байх;

- 2.3.2.эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан байх;
- 2.3.3.иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн байх;
- 2.3.4.байгаль орчинд ээлтэй байх;
- 2.3.5.үр ашиг, хэмнэлттэй байх;
- 2.3.6.шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан байх.

### **Гурав.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах стратегийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх зорилт**

3.1.Монгол Улсын эрчим хүчний нөөц боломж, тулгамдаж байгаа асуудалд үндэслэн Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод дараах стратегийн зорилгыг дэвшүүлж байна:



**Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах тэргүүлэх чиглэлийн хүрээнд:**

3.1.1.эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах;

3.1.2.бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.1.3.эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах.

**Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд:**

3.1.4.эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх;

3.1.5.эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.

**Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн хүрээнд:**

3.1.6.сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.

3.2.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг дэвшүүлж байна:

3.2.1.стратегийн нэгдүгээр зорилго буюу эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах хүрээнд:

3.2.1.1.анхдагч эрчим хүч, түлшний хангамжийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;

3.2.1.2.эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох;

3.2.1.3.эрчим хүчний нэгдсэн системийн цахилгааны ачааллын хэлбэлзлийг тохируулж, хэвийн найдвартай ажиллагааг хангах тохируулгын эх үүсвэрийг бий болгох;



3.2.1.4.хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх;

3.2.1.5.бүс нутгийн эрчим хүчний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;

3.2.1.6.цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах.

3.2.2.стратегийн хоёрдугаар зорилго буюу бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд:

3.2.2.1.хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай гэрээ байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.2.2.2.олон улсын байгууллага, бүс нутгийн орнуудын эрчим хүчний хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхтэй оролцох, хамтран ажиллах;

3.2.2.3.Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах;

3.2.2.4.эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах.

3.2.3.стратегийн гуравдугаар зорилго буюу эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах хүрээнд:

3.2.3.1.эрчим хүчний инженер-техникийн ажилтан бэлтгэх дотоодын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулах, салбарын инженер-техникийн ажилтан, менежерийн чадамжийг олон улсын түвшинд хүргэх;

3.2.3.2.эрчим хүчний эдийн засаг, үйлдвэрлэл, туршилт, тохируулгын судалгаа, хөгжлийн үндэсний хүрээлэнг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;



3.2.3.3.эрчим хүчний салбарын хүний нөөцийн балансыг зохистой түвшинд хадгалан удирдлагын бүх түвшинд мэргэжлийн боловсон хүчний шаталсан байршуулалтын тогтолцоог мөрдөх.

3.2.4.стратегийн дөрөвдүгээр зорилго буюу эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх хүрээнд:

3.2.4.1.бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифийн тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах;

3.2.4.2.эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2.4.3.эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3.2.5.стратегийн тавдугаар зорилго буюу эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:

3.2.5.1.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд бүрэн шилжүүлж нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох;

3.2.5.2.эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

3.2.5.3.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээн дэх алдагдлыг бууруулах;

3.2.5.4.үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх;

3.2.5.5.эрчим хүчний хэрэглээ тооцох механизмыг бүрэн хэмжүүржүүлэх.

3.2.6.стратегийн зургадугаар зорилго буюу сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүрээнд:



3.2.6.1.Монгол орны сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус, газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний нөөцийг нарийвчлан тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэ техник, технологийн судалгаа, шинжилгээ хийх байгууллагыг хөгжүүлэх;

3.2.6.2.эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх;

3.2.6.3.сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг бий болгох;

3.2.6.4.айл өрх, аж ахуйн нэгж, алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглах, илүүдэл эрчим хүчээ сүлжээнд нийлүүлэхийг дэмжих;

3.2.6.5.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах;

3.2.6.6.байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах.

**Дөрөв.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, удирдлага зохион байгуулалт, үнэлгээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн**

4.1.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

**Нэгдүгээр үе шат /2015-2023 он/:** түлш, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурийг бий болгох, эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах үе.

4.1.1.Нэгдүгээр үе шатанд хүрэх үр дүн: Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, үр ашиг өндөртэй өндөр параметрийн тоноглолыг ашиглаж эхлэх бөгөөд нийт суурилагдсан чадлын 10-аас доошгүй хувийг усны эх үүсвэрээр бүрдүүлж, нөөц чадлыг 10 хувьд хүргэн, сэргээгдэх эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлэх



нөхцөлийг бүрдүүлнэ. Бодит үнэ тарифын тогтолцоог бий болгож, эрчим хүчний салбарыг эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1.1.Улаанбаатарын 5 дугаар дулааны цахилгаан станц, Тавантолгойн, Багануурын дулааны цахилгаан станцууд баригдсан байх;

4.1.1.2.экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн байх;

4.1.1.3.системийн горим тохируулах Эгийн голын усан цахилгаан станц баригдсан байх;

4.1.1.4.баруун бүсэд дулааны цахилгаан станц, Ховд голд усан цахилгаан станц, зүүн бүсэд Дорнодын дулааны цахилгаан станц баригдсан байх;

4.1.1.5.Багануур - Чойр, Улаанбаатар - Мандалговь, Багануур - Улаанбаатар, Багануур – Өндөрхаан - Чойбалсан, Чойр - Сайншанд, Мандалговь - Арвайхээр, Дөргөн - Улиастай - Улаанбаатарын бүс нутгийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугамууд баригдсан байх;

4.1.1.6.эрчим хүчний үнэ тариф индексжин, эрчим хүчний салбар зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллаж, санхүүгийн хувьд бие даасан байх;

4.1.1.7.дамжуулах сүлжээг төрийн өмчлөлд хадгалан, түгээх, хангах үйл ажиллагаа, төрийн өмчит эрчим хүчний үйлдвэрүүдийг нээлттэй хувьцаат компани болгох замаар үе шаттайгаар хувьчилсан байх, эрчим хүчний салбарын хувьчлагдсан үйлдвэрүүдийг техник технологи, өргөтгөл шинэчлэлдээ зориулж санхүүжилт босгоход төрөөс дэмжих тогтолцоо бүрдсэн байх;

4.1.1.8.дотоодын эрчим хүчний судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн үйл ажиллагаа нь тогтмолжиж, эрчим хүчний мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах сургалтын байгууллагуудын сургалтын чанар, стандарт хөгжингүй орнуудын жишигт хүрсэн байх;

4.1.1.9.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны үйлдвэрлэлийн автоматжуулалт, мэдээллийн хяналт удирдлагыг цогц системд шилжүүлж эхэлсэн байх.



**Хоёрдугаар үе шат /2024-2030 он/:** Цахилгаан эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчийг тогтвортой хөгжүүлэх үе.

4.1.2.Хоёрдугаар үе шатанд хүрэх үр дүн: Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн аюулгүйн нөөцийг 20-оос доошгүй хувьд хүргэж, нийт суурилагдсан чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ 30 хувьд хүрнэ. Бүсүүдийг өндөр хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугамаар холбож, мэдээллийн хяналт удирдлагыг цогц систем бүхий эрчим хүчний нэгдсэн ухаалаг системийг бий болгоно. Түгээх, хангах сүлжээг бүрэн хувьчилж, эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөний зарчмаар ажиллуулна. Хөрш орнуудтай их чадлын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамаар холбогдож цахилгаан эрчим хүч экспортлох үе. Үүнд:

4.1.2.1.Монгол Улсыг бүхэлд нь хамарсан эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдсан байх;

4.1.2.2.Сэлэнгэ мөрний ай савд том чадлын усан цахилгаан станц, өмнөд бүсэд нийт 300 МВт чадалтай салхин парк, нарны станцууд, экспортын зориулалтын том чадлын цахилгаан станц, дамжуулах шугам баригдсан байх;

4.1.2.3.эрчим хүчний чанар, тасралтгүй найдвартай хангамж хөгжингүй орнуудын жишигт хүрэх;

4.1.2.4.Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний худалдаанд идэвхтэй оролцогч орнуудын нэг болсон байх;

4.1.2.5.инноваци, өндөр технологийн чиглэлээр эрчим хүчний үндэсний судалгааны тогтолцоо бий болсон байна;

4.1.2.6.эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал, нийт үйлдвэрлэлд хувийн хэвшлийн оролцоо давамгайлсан байх;

4.1.2.7.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны үйлдвэрлэлийн автоматжуулалт, мэдээллийн хяналт удирдлагыг цогц системд бүрэн шилжүүлж, нэгдсэн ухаалаг сүлжээтэй болсон байх.

4.2.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2014 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ:





Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоон хэмжээ		
	2014 он /суурь он/	Нэгдүгээр үе шат /2023 оны түвшинд/	Хоёрдугаар үе шат /2030 оны түвшинд/
Цахилгаан үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадлын нөөц	-10%	10%-иас багагүй	20%-иас багагүй
Томоохон хотуудын дулааны эх үүсвэрийн чадлын нөөц	3%	10%-иас багагүй	15%-иас багагүй
Төвийн бүсийн цахилгааны үнийн бүтцэд ногдох ашгийн хэмжээ	-16.22%	0%	5%
Дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээ	14.4%	11.2%	9.14%
Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал /Оюутолгойн импорт ороогүй/	13.7%	10.8%	7.8%
Дотоодын хэрэгцээний нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ	7.62%	20%	30%
1 Гкал эрчим хүч үйлдвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээ	0.52 тонн CO <sub>2</sub> эквивалент	0.49 тонн CO <sub>2</sub> эквивалент	0.47 тонн CO <sub>2</sub> эквивалент
Барилгын дулааны алдагдлыг бууруулах хэмжээ	0%	20%	40%
Эрчим хүчний үйлдвэрлэлд нэвтэрсэн байх технологийн дэвшил	Өндөр даралтат технологи	Саб критикал даралтат технологи, Байгалийн хийг ашиглах, Их чадлын цэнэг хураагуурын систем, ус хуримтлуурын станц	Супер критикал, хэт супер критикал даралтат технологи, Устөрөгч ашиглах, Нарны илчийг ашиглах технологи



## **Тав.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын хэрэгжилт, санхүүжилтийн эх үүсвэр**

5.1.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь дунд хугацааны эрчим хүчний үндэсний хөтөлбөрөөр тодорхойлогдох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

5.2.Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх суурь дэд бүтцийг бүрдүүлдэг, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай стратегийн салбарын хувьд хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг төрөөс тэргүүн ээлжид анхаарна.

5.3.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

5.3.1.төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.3.2.хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах;

5.3.3.улсын төсөв, хөрөнгө оруулалтын хөтөлбөр;

5.3.4.олон улсын санхүүгийн байгууллагын хамтын ажиллагаа;

5.3.5.зээл;

5.3.6.бусад эх үүсвэр.

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2015 оны 06 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар  
хот

### **Шүүгч нарыг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан энэхүү зарлигийн хавсралтад дурдсан нэр бүхий хүмүүсийг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2015 оны 06 дугаар сарын 30–ны өдрийн  
110 дугаар зарлигийн хавсралт

**Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх:**

1. Лхүндэвийн Наранбаярыг Иргэний хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Ядамсүрэнгийн Алтаннавч, Дорждэрэмийн Байгалмаа, Зундуйн Энхцэцэг нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Гомбын Лхагвамааг Иргэний хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Хишгээгийн Байгалмаа, Нэргүйн Батчимэг нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3. Пандийн Долгормааг Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Нямдоржийн Насанжаргал, Цогт-Очирын Отгонцэцэг, Шагдаргомбын Төмөрбаатар нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Гомбын Адъяаотогтох, Түндэвийн Даваасүрэн, Лоолгойн Нямдорж, Готовын Уламбаяр нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

5. Бадамдоржийн Ариунбаярыг Иргэний хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Төмөрпүрэвийн Жаргалсайхан, Доржийн Тайванхүү нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

6. Оросоогийн Нарангэрэлийг Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Солтанмуратын Өмирбек, Өкейн Сауле, Нямжавын Туяа нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

7. Ёндонгийн Бямбацэрэнг Иргэний хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Сампилын Уранчимэг, Маруушийн Хүрэлбаатар, Цэвээндөөгийн Өрнөндэлгэр нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;



8. Банзрагчийн Оюунцэцэгийг Иргэний хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Нямаагийн Баярхүү, Төмөрбаатарын Ганбат, Авирмэдийн Отгонцэцэг нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

9. Буурайн Баттөрийг Иргэний хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Лувсандашийн Амарсанаа, Гөлгөөгийн Давааренчин, Сүнжидмаагийн Оюунцэцэг, Сосорбарамын Энхжаргал нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

10. Намсрайн Батзориг, Гоошоохүүгийн Даваадорж, Дашцоодолын Дэлгэрцэцэг, Энэбишийн Золзаяа, Цэнд-Аюушийн Ичинхорлоо, Азуйсэдийн Мөнхзул, Мянгаагийн Наранцэцэг, Жаргалсайханы Оюунтунгалаг, Шаравын Оюунханд, Чимэдрэгзэнгийн Оюунцэцэг, Дашнямын Цогтсайхан, Сономдовчингийн Энхтөр нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

**Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх:**

1. Арвинбуянгийн Энхбаатарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Одонгийн Баатарсүх, Борын Дэнсмаа, Гун-Аагийн Сүрэн, Базаргарьдын Сүхгомбо нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Нопын Болормааг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Гэндэндоржийн Болормаа, Адилбишийн Сайнтөгс, Гэрэлийн Тэгшсуурь нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3. Тогооборын Бямбажавыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Халзанхүүгийн Гэрэлмаа, Гаажидын Дэлгэрбямба, Рашзэвэгийн Мөнх-Эрдэнэ нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Данзангийн Эрдэнэбилэгийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Намсрайн Гачмаа, Магнайбаярын Мөнхдаваа, Сүрэнхорлоогийн Өсөхбаяр нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;



5. Жигдэнгийн Баттогтохыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Батлайн Намхайдоржийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

6. Дагвын Жамбалсүрэнг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Бэгзийн Дамба, Надмидын Мөнхжаргал, Мөнхбаярын Нямбаяр нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

7. Пүрэвсүрэнгийн Батсайханыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Цэдэн-Ишийн Туяа, Сандагийн Цэцэгмаа нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

8. Зундуйн Хосбаярыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Батчулууны Сосорбарам, Сүхээгийн Уранчимэг, Түндэвийн Энхмаа нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

9. Батжаргалын Батзоригийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Цээлийн Амаржаргал, Дагвадоржийн Буянжаргал, Банзайн Манлайбаатар, Ядамсүрэнгийн Туул нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

10. Лувсаншаравын Даваасүрэнг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Намдагсүрэнгийн Батсайхан, Ширэндэвийн Бат-Эрдэнэ, Дамдинсүрэнгийн Гансүх, Баасанжавын Зориг, Даваахүүгийн Мөнхтуул, Дарамын Мягмаржав, Цогийн Оч, Довдонгийн Очмандах, Дагвын Оюунчулуун, Төмөрбаатарын Өсөхбаяр, Мөнхөөгийн Пүрэвсүрэн, Сосорбурамын Соёмбо-Эрдэнэ, Очирбатын Чулуунцэцэг нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

**Гурав. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх:**

1.Бямбаагийн Мөнхтуяаг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;



Доржгочоогийн Баатархүү, Дэмбэрэлийн Батбаатар, Энхбатын Зоригтбаатар, Сосорын Мөнхжаргал, Очирбатын Номуулин, Бямбаагийн Тунгалагсайхан, Энхтуяагийн Халиунбаяр, Ноостын Хонинхүү, Цэндийн Цогт нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

**Дөрөв. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх:**

1. Бавалын Баатарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Цэвээндоржийн Алтанцэцэг, Санжаагийн Амардэлгэр, Жагарын Байгалмаа, Ганзоригтын Билгүүн, Могнооны Болормаа, Содномтүнрэвийн Буд, Дамдинжавын Ганболд, Дашцэрэнгийн Даваасүрэн, Чойндонгийн Даваасүрэн, Намсрайн Нарангэрэл, Намжилсүрэнгийн Оюунтуяа, Бадарчийн Сайханцэцэг, Нарантуяагийн Сарангүн, Дамдинжавын Солонго, Баярсайханы Ундраа, Баатарын Ууганбаяр, Өлзийн Уянга, Сэнгээгийн Хишигбат, Батбаярын Цолмонбаатар, Бямбаюугийн Цолмонгэрэл, Жалцангийн Цэнгэл, Цэрэндашийн Цэрэндулам, Сэргэлэнгийн Энхбаяр, Лувсандоржийн Энхжаргал, Төмөртоогоогийн Энхжаргал, Довжилжамцын Энхтуяа, Төмөрсүхийн Энхтуяа, Эрдэнэчимэгийн Энэбиш нарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Жамсранжавын Эрдэнэчимэгийг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Равдандоржийн Алтантуяа, Эрдэнэбатын Амин-Эрдэнэ, Бямбаагийн Ариунхишиг, Дагаагийн Байгалмаа, Түмэндэлгэрийн Батсүх, Намдагсүрэнгийн Батчимэг, Мянгаагийн Баясгалан, Тогтохын Гандиймаа, Занын Доржнамжин, Ванчигдоогийн Жавхлан, Жуумаагийн Кульдана, Доржсүрэнгийн Мөнгөнтуул, Батнасангийн Мөнхжаргал, Чулуунбаатарын Мөнхцэцэг, Дансрангийн Наранцэцэг, Дашцоодолын Нямбазар, Цэрэнпагамын Оюунбилэг, Шонхойн Оюунтуул, Цэдэн-Ишийн Сансармаа, Адъяахүүгийн Сарантуяа, Жигжидсүрэнгийн Сэлэнгэ, Жамъяанчойжилын Сэмжид, Тогтохын Туяа, Дамдинсүрэнгийн Уранзул, Батсүрэнгийн Хишигбаатар, Дамбадаржаагийн Хулан, Чулуунбаатарын Цэнд, Дэмчигийн Энхцэцэг нарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн албан тушаалаас;

3. Пунцагийн Цэцэгдуламыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Ганбатын Ариунаа, Төмөрбаатарын Ганчимэг, Пүрэвийн Туяа, Төмөрбаатарын Эрдэнэтунгалаг нарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Батдоржийн Нармандахыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;



Нямсүрэнгийн Баярсүрэн, Зоригтын Түвшинтөгс, Данжаадын Уранчимэг, Лхагвадоржийн Энхбилэг нарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

**Тав. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:**

1. Мөнхбаярын Алдарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Чойнорын Алтанцэцэг, Содномдаржаагийн Батжаргал, Загдаагийн Болдбаатар, Гомбосүрэнгийн Буяннэмэх, Ийшээгийн Ганбат, Хувьтөгөлдөрийн Идэр, Батбаярын Мөнхбаяр, Баярын Мөнх-Эрдэнэ, Санги-Очирын Олзод, Чулуунбаатарын Отгонбаяр, Самбуугийн Оюунгэрэл, Сүхээгийн Оюунчимэг, Сумъяагийн Пүрэвсүрэн, Барьны Сарантуяа, Шадравын Төгсгэрэл, Үржинбадамын Түмэнжаргал, Боролзойн Халиун, Цолмонгийн Цэлмэг, Төрбатын Шинэбаяр нарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Ёндонгийн Цогтзанданг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Довчинсэнгээгийн Алтанжигүүр, Түмэн-Өлзийн Алтантуяа, Амаржаргалын Алтанхуяг, Гаанжуурын Алтанцэцэг, Лхамхүүгийн Баатар, Сайнбаярын Базарханд, Бадамрагчаагийн Батболор, Сэлэнгийн Батгэрэл, Дэндэвийн Батсуурь, Гомбодоржийн Ганбаатар, Лувсандашийн Гансүх, Цэгмидийн Дайрийжав, Банзрагчийн Дашдондов, Гансүхийн Есөн-Эрдэнэ, Осордэлэгийн Жанчивнямбуу, Намжилдоржийн Мөнхбаяр, Гантөмөрийн Мөнхзул, Магсарын Нармандах, Хашхүүгийн Одбаяр, Лхам-Янжингийн Оюун, Лханаажавын Оюунчимэг, Цэвэгдоржийн Оюунчимэг, Пагамын Туяат нарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3. Дамдинсүрэнгийн Оюунбатыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Баасанжавын Байгалмаа, Алтангэрэлийн Бямбажав, Намширын Нарантуяа нарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Нямдоржийн Одонтуулыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Дансрангийн Бавуу, Дорлигийн Лувсандорж, Дүвчингийн Чинзориг нарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;



### **Зургаа. Захиргааны хэргийн анхан шатны шүүх:**

1. Баттулгын Одонтуяаг Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Сарантуяагийн Ганбат, Лхагвасүрэнгийн Өлзийжаргал нарыг Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Зукарын Гүльбаршааг Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Сейтмуратын Еркеш, Махайн Риза нарыг Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3. Сангибатын Сайнбилэгийг Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Чулуунбатын Оюунсайхан, Цэдэвийн Сувдмаа нарыг Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Шаравын Баттогтохыг Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Энхжаргалын Золбадрах, Бадамдоржийн Саранчимэг нарыг Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

5. Зоригтбаатарын Ганзориг, Нанзадын Дамдинсүрэн, Бямбасүрэнгийн Мөнхзул нарыг Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

6. Далантайн Нарантуяаг Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Жалбаагийн Бурмаа, Лидагийн Одбаатар, Жамъянхоролын Оюунчимэг, Зундуйн Энхтуяа нарыг Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

7. Сураагийн Отгонтуяа, Балжиннямын Сийлэгмаа, Баярын Цэнд нарыг Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

8. Батбаярын Оюуныг Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Паламын Амаржаргал, Сэнгэдоржийн Оюунтунгалаг нарыг Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;





9. Буянтгогтохын Сугиржавыг Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Лхагвадуламын Батбаатар, Володягийн Цэрэнрагчаа нарыг Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

10. Лхагважаргалын Тунгалагийг Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Нямын Амарзаяа, Чулуунбаатарын Цэнд-Очир нарыг Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

11. Баттуулайн Болормааг Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Гомбодоржийн Гантуяа, Батбаярын Мөнхжаргал, Доржийн Сарангэрэл, Пүрэвсүрэнгийн Ууганцэцэг нарыг Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

12. Сангаагийн Отгонцэцэгийг Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Чинзоригийн Баярмаа, Могнооны Цэцэгмаа нарыг Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

13. Цэдэн-Ишийн Нэргүйг Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Бат-Эрдэнийн Батчимэг, Баясахын Сугар нарыг Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

14. Хаянхярваагийн Эрдэнэтуяаг Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Бяхаржавын Баярцогт, Бавуугийн Цэрэнханд нарыг Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

15. Бат-Өлзийн Хажидмааг Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Чирчингийн Одсүрэн, Доржготовын Чанцалням нарыг Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

16. Түмэнжаргалын Оюунгэрэлийг Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;



Дүгэрсүрэнгийн Алтанцэцэг, Уртнасангийн Бадамсүрэн нарыг Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

17. Гомбосүрэнгийн Сонинболорыг Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Сономпилын Оюунгэрэл, Ганболдын Янжиндулам нарыг Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

18. Балжирхүүгийн Энхтайванг Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Жамсранжавын Ганчимэг, Тогтохдоржийн Долгорсүрэн нарыг Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

19. Намсрайн Балжмааг Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Ганбатын Баясгалан, Бямбаагийн Мөнх-Эрдэнэ нарыг Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

20. Цэрэннадмидын Батсүрэнг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Баатарын Адъяасүрэн, Мишигдоржийн Батзориг, Намжилын Долгорсүрэн, Нэрэндашийн Дуламсүрэн, Дамдинсүрэнгийн Зоригтбаатар, Эрдэмбилэгийн Лхагвасүрэн, Амгалангийн Насандэлгэр, Даваанямын Оюумаа, Оюунбатын Оюунгэрэл, Цолмонгийн Сайхантуяа, Александрийн Сарангэрэл, Сандагдоржийн Төмөрбат, Дашравдангийн Халиуна нарыг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

#### **Долоо. Сум дундын шүүх:**

1. Ванд-Очирын Цэцэнбилэгийг Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Раднаасамбуугийн Алтанцэцэг, Төмөрбаатарын Бадрах, Доржийн Байгалмаа, Дагийшаравын Бямбасүрэн, Пэрлээгийн Гандолгор нарыг Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Дашдоржийн Мөнхөөг Сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Кадирбекийн Бүлдирген, Акраны Дауренбек, Хабыкейн Жардемхан, Батбайн Мангилик, Халамханы Мейрамбек нарыг Сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;



3. Батаагийн Гэрэлмааг Сум дундын 3 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Нацагийн Баасанбат, Чулуунбаатарын Байгалмаа, Батмөнхийн Болор-Эрдэнэ, Лхагвасүрэнгийн Нарангэрэл нарыг Сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4. Содовын Цэрэндуламыг Сум дундын 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Лхагвасүрэнгийн Дарьсүрэн, Жаргалын Дэлгэрмөрөн, Ганбаатарын Мягмарсүрэн, Сүрэнгийн Цэрэнханд нарыг Сум дундын 4 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

